



**ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Журам батлах тухай

“Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.5, 9.9.10, “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.29 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн тусгай зөвшөөрөл олгоход урьдчилсан дүгнэлт, үнэлгээ өгөх, ажил, үйлчилгээ гүйцэтгэх журмыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга (Т.Солонго)-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.БЯМБАСҮРЭН

Эрчим хүчний үндэсний төвийн Гүйцэтгэх
захирлын 2025 оны 01 сарын 30 өдрийн
А/11 тоот тушаалын хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ ӨГӨХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь ААН, хуулийн этгээдийн Эрчим хүчний барилга байгууламж (эх үүсвэр, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, зуух, даралтат сав, дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төв) -ийн зураг төсөл боловсруулах, барилга угсралт, засвар, туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшихээр гаргасан хүсэлтийг цахим системээр хүлээн авах, судлах, холбогдох шийдвэрийн санал гаргах, хариу хүргүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Эрчим хүчний тусгай зөвшөөрлийн цахим мэдээллийн систем нь www.license.energy.gov.mn гэсэн хаягтай байх бөгөөд Стандарт хэмжил зүйн газраас батлагдсан Монгол улсын стандартыг баримтлан ажиллана.
- 1.3. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.1-14.22 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрлийг өргөдлийн материалыг хүлээн авах, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах ажлыг зохион байгуулан ажиллана.
- 1.4. Тусгай зөвшөөрөл олгоход урьдчилсан дүгнэлт, үнэлгээ өгөх ажил, үйлчилээний жишиг хөлсийг Гүйцэтгэх захирлын тушаалаар батална.
- 1.5. Тусгай зөвшөөрлийг олгоход урьдчилсан дүгнэлт, үнэлгээ өгөх ажил, үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн албаны үндсэн үйл ажиллагаа

- 2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хүсэгч ААН-ийн өргөдөл, материалыг цахим системээр хүлээн авч, эрчим хүчний тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөл, шаардлага хангасан эсэхийг хянаж ажиллана. Үүнд:
 - 2.1.1. Тусгай зөвшөөрлийн цахим мэдээллийн системд материал хүлээн авсан ААН, байгууллагын баримт бичгийг нягтлан шалгаж мэдээллийг нэгтгэн боловсруулах,
 - 2.1.2. Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан компаниудын баримт бичгийг магадлан шалгасан ажлын тайланг Эрчим хүчний яаманд тухай бүр хүргүүлэх,
 - 2.1.3. Тусгай зөвшөөрөл олгох Эрчим хүчний сайдын тушаал, шийдвэрийг үндэслэн харилцагч ААН, байгууллагатай гэрээ байгуулах,
 - 2.1.4. Шаардлага хангасан ААН, байгууллагад тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хүлээлгэн өгч ажиллах,

2.2. Тусгай зөвшөөрөлтэй холбогдох асуудлаар www.license@energy.gov.mn и-мэйл хаягаар болон албаны 77113040 утсаар харилцагчдаас ирсэн санал, хүсэлтэд тогтмол хариу өгч ажиллах,

2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллах,

2.4. Тусгай зөвшөөрөлтэй холбогдох асуудлаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх, техникийн асуудлыг шийдвэрлүүлэх,

2.5. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан гомдлыг арилгах тэдгээрийн үйл ажиллагааны талаар тодорхойлолт, санал гаргах

Гурав. Тусгай зөвшөөрлийг олгоход урьдчилсан дүгнэлт,
үнэлгээ өгөх ажлын нэр төрөл, үйлчилгээний хөлс

3.1. Эрчим хүчний эх үүсвэр, шугам, сүлжээ, зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох ажлын хүрээнд ажил, үйлчилгээний хүчин чадлаас хамаарч дараах үйлчилгээний хөлсийг тогтоосон. Үүнд.

Д/д	Үйл ажиллагааны төрөл	Үйлчилгээний 1 жилийн хөлс /төгрөг /
1	Эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах	200 000₮-2400 000₮
2	Цахилгаан дамжуулах, түгээх шугам, дэд станцын угсралт, засварын ажил, туршилт тохируулгын ажил үйлчилгээ	400 000₮-1200 000₮
3	Зуухны угсралт, засварын ажил, туршилт тохируулгын ажил үйлчилгээ	200 000₮-800 000₮
4	Даралтат савны угсралт засварын ажил, туршилт тохируулгын ажил үйлчилгээ	200 000₮-800 000₮
5	Дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засварын ажил, туршилт тохируулгын ажил үйлчилгээ	200 000₮-800 000₮
6	Даралтад ажилладаг тоноглолуудын угсралт, засварын ажил, туршилт тохируулгын ажил үйлчилгээ	200 000₮
7	Эрчим хүчний байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд:	1000 000₮

3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн эрхийн бичгийг санамсаргүйгээр үрэгдүүлсэн тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан хүчингүй болгосон тохиолдолд гэрчилгээг шинээр авахдаа гэрчилгээний үнэт цаасны үнийг төлнө.

3.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд нэмэлт ажлын төрөл авах нөхцөлд ажилбарын үнийн зөрүүг нэмж төлнө.

3.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн үйл ажиллагаа өөрчлөгдөөгүй боловч нэр өөрчлөгдсөн тохиолдолд гэрчилгээний үнэт цаасны үнийг төлнө.

3.5. Эрчим хүчний чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд

заасны дагуу төлбөрийг Төрийн сангийн дансанд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулна.

3.6. Тусгай зөвшөөрлийн сунгалт хийж байгаа тохиолдолд Нормчлолын санд ногдох шимтгэлийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулна.

3.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлсөн үйлчилгээний хөлсөнд НӨАТ-ын баримт олгоно.

Дөрөв. Тусгай зөвшөөрлийг олгоход урьдчилсан дүгнэлт, үнэлгээ өгөх ажил, үйлчилгээний орлогыг зарцуулах үйл ажиллагааны төрөл

4.1 Эрчим хүчний тусгай зөвшөөрлийн үйлчилгээний хөлсийг тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ хийх, гэрээний хэрэгжилтийг хангах, орлогыг төвлөрүүлэх, данс бүртгэл хөтлөх, гадаад харилцааг хөгжүүлэх, мэргэжил, чадварыг дээшлүүлэх, техник технологийн шинэ шийдэл гаргах, ажилчдын нийгмийн асуудал шийдэх, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх шаардлагаар дараах үйл ажиллагаанд зарцуулна.

4.1.1. Тусгай зөвшөөрөл хүсэгчийн холбогдох материалыг архивлах, тусгай зөвшөөрлийн үнэт цаас хэвлүүлэх,

4.1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өргөдөл хүлээн авах, цахим системийн шинэчлэлт, хөгжүүлэлт, техник, тоног төхөөрөмж худалдан авах зардал,

4.1.3. Эрчим хүчний салбарын хэмжээнд зохион байгуулагдах хурал, сургалт, семинар, түүнийг зохион байгуулахтай холбогдсон зардал

4.1.4. Хууль тогтоомж, дээд байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангуулах болон байгууллагын шийдвэрийн дагуу явах холбогдох албан тушаалтнуудын гадаад дотоод албан томилолт,

4.1.5. Тусгай зөвшөөрлийн программ хангамж сайжруулах зэрэг ажлыг гүйцэтгэх,

4.1.6. Батлагдсан бүтэц орон тоонд ажиллагсдын цалин хөлс, урамшууллын зардал,

4.1.7. Тухайн орлогыг төвлөрүүлэхтэй холбогдон гарсан байгууллагын ашиглалт хураамжийн зардалд тус тус зарцуулна.

4.2 Тусгай зөвшөөрлийн албаны тухайн жилийн төлөвлөгөөт орлогоос давуулан биелэгдсэн нөхцөлд зохих урамшууллыг олгоно.

4.2.1 Төлөвлөснөөс давсан орлогын дүнгээс 20 хүртэл хувиар тусгай зөвшөөрлийн ажлын хэсэг болон ажлын албаны гишүүдийг урамшуулж болно.

4.2.2 Урамшууллын хувь хэмжээг Санхүү, эдийн засгийн хэлтэс баталгаажуулснаар гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.

4.2.3 Төлөвлөгөөг биелүүлээгүй тохиолдолд урамшуулал олгохгүй.

4.3 Ажил үйлчилгээний цэвэр ашгаас ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэж болно.

--- oooOooo---